

Мэдээллийг нийтлэх, олон нийтэд ил болгох ерөнхий зөвшөөрөл хүсэх тухай

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа,

Сургууль/Боловсролын Яам нь таны хүүхдийн туршлагыг бусад сурагчидтай хуваалцах, сургууль болон сурагчийн үйл ажиллагааны талаар сургууль болон олон нийтэд мэдээлэх, мөн түүнчлэн онцлох төсөл болон олон нийтийн ажилд сурагчийн оролцоог тэмдэглэн үлдээх зорилгоор сурагчийн талаарх мэдээллийг нийтлэх болон/эсвэл нийтэд ил болгох зөвшөөрлийг авахыг хүсч байна.

Энэ мэдээлэлд таны хүүхдийн овог нэр, нас, анги болон таны хүүхдийн гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, таны хүүхдийн бүтээл, интерактив мэдээллийн хэрэгсэлд санал бодлоо илэрхийлсэн байдал гэх мэт сургуульд цуглуулсан мэдээлэл багтаж болно.

Таны хүүхдийн дараах мэдээллийг бид хэвлэн нийтлэх, эсвэл нийтэд ил болгохоос гадна нэмэлт мэдээллүүд байж болно:

- Сургуулийн вэб сайт, Боловсролын Яамны дотоод сүлжээ (зөвхөн өөрийн ажилтнуудад зориулсан), блог, вики зэрэг Боловсролын Яамны олон нийтийн вэбсайтууд
- Сургуулиас гаргадаг мэдээллийн товхимол, жил бүрийн сургуулийн сэтгүүл, сургуулийн тайлан зэрэг Боловсролын Яамны хэвлэлүүд, цаасаар болон цахим хэлбэрээр хэвлэгдсэн сурталчилгааны материалууд. Үүнд уг яамны вэбсайтууд мөн багтана.
- Facebook, Twitter зэрэг сүлжээн дэх Яамны болон сургуулийн албан ёсны сошиал медиа хаягууд
- Орон нутаг, нийслэлийн сонин, сэтгүүл, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл.

Олон нийтийн цахим хуудсууд болон олон нийтийн мэдээллийн сувгуудад мэдээлэл нийтлэгдсэн тохиолдолд байнгын биш юмаа гэхэд хэдэн жилийн турш онлайнгаар харагдах боломжтой гэдгийг эцэг эхчүүд мэдэж байх ёстой. Хайлтын системүүд нь нийтлэгдсэн мэдээллийн хуулбарыг нуух эсвэл хадгалах боломжтой. Мөн нийтлэгдсэн мэдээлэл гуравдагч этгээдийн вэб хуудастай холбогдсон байх боломжтой.

Зөвшөөрлийн маягыг бөглөж, дараах хугацаанд сургууль руу явуулна уу:

Date for return of permission form

Орчуулагчийн туслалцаа

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдоно уу.

Сургуультай холбогдох орчуулагчийн туслалцаа хэрэгтэй бол 131 450 дугаарт холбогдож, операторт ямар хэлний туслалцаа хэрэгтэйг хэлж, сургуультай холбож өгөхийг хүснэ үү. Оператор танд туслах орчуулагчийг холбох болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Хүндэтгэсэн,

Захирлын нэр (Name of principal)

Сургуулийн нэр (Name of school)

Мэдээллийг нийтлэх эцэг эх/асран хамгаалагчийн зөвшөөрөл Parent/carer permission to publish consent

Би мэдээллийг нийтлэх уг зөвшөөрлийг уншсан бөгөөд:

(Доорх тэмдэглэгээнээс нэгийг сонгож бусдыг нь хоосон орхино уу)

Сургууль/Боловсролын Яам манай хүүхдийн талаарх мэдээллийг дээр дурдсанчлан нийтлэхийг би зөвшөөрч байна.

I give permission to the school/Department of Education to publish information about my child as described above, including in publicly accessible communications.

Би сургууль/Боловсролын газар манай хүүхдийн талаарх мэдээллийг дээр дурдсанчлан нийтлэхийг зөвшөөрөхгүй.

I do not give permission to the school/Department of Education to publish information about my child as described above, including in publicly accessible communications.

Энэхүү гарын үсэг зурсан зөвшөөрөл нь намайг сургуульд санал бодлоо өөрчилснөө мэдэгдэх хүртэл хүчинтэй хэвээр байна.

Хүүхдийн нэр (дармалаар бичнэ үү)

Name of child

Эцэг эх/асран хамгаалагчийн нэр
(дармалаар бичэн үү)

Name of parent/carer

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг

Signature of parent/carer

Огноо

Date